

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ХОРШООДЫН 2011 ОНЫ ХОЁРДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2011.09.07

Улаанбаатар хот

НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

Хорооны хуралдаанаар 2011 оны эхний хагас жилийн байдлаар 2 хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 10 хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй¹ болгож, 4 хоршооны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 21 хоршооны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаар шийдвэрлэсэнээр 2011 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт 171 хоршоо Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Харин тайлант улиралд 7 хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 2 хоршооны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 13 хоршооны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаар шийдвэрлэсэн байна.

Хоршоодын гишүүдийн тоог графикаар үзүүлбэл:



Хорооны хуралдаанаар хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын асуудлыг шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

Онууд	шинээр олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	түдгэлзүүлснийг сэргээсэн	ТЗ-ийн хугацаа сунгасан	Хоршоодын тоо
2006	51	0	0	-	-	51
2007	128	0	0	-	-	179
2008	45	15	5	-	-	209
2009	15	12	8	1	25	212
2010	2	35	15	4	80	179
2011-1	2	3	2	-	8	178
2011-2	0	7	2	-	13	171


¹ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1.4 /тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн/, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 25.1.8 /тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжийг ноцтой буюу удаа дараа зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг хичингүй болгох талаар Хороонд санал оруулах/.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2.1 Нэгдсэн үзүүлэлтүүд

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны II улирал	2010 оны II улирал
1	Хоршоодын тоо	171	190
2	Гишүүдийн тоо	26,329	25,452
3	Нийт актив /мян.төг/	53,250,493.5	45,595,146.0
	Банкны салбарт эзлэх хувь	0.7%	0.9%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	40,453,722.9	35,481,217.6
	Банкны салбарт эзлэх хувь	0.9%	1.2%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мян.төг/	2,913,278.8	3,400,226.2
	Банкны салбарт эзлэх хувь	0.8%	0.9%
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл /мян.төг/	37,920,340.1	31,011,243.7
	Банкны салбарт эзлэх хувь	1.1%	1.6%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэл /мян.төг/	7,870,158.5	7,220,707.7
	Банкны салбарт эзлэх хувь	3.0%	2.6%
8	Өөрийн хөрөнгө /мян.төг/	11,724,523.6	10,636,819.5
	Банкны салбарт эзлэх хувь	2.3%	2.1%
9	Хоршоологчдын өмч /мян.төг/	3,854,365.0	3,416,111.9
10	Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мян.төг/	435,257.1	558,558.8
11	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мян.төг/	49,600.0	230,318.6
12	Нийт орлого /мян.төг/	6,318,789.0	5,973,373.8
13	Нийт зардал /мян.төг/	5,536,681.3	5,779,951.8
14	Тухайн үеийн ашиг, алдагдал /мян.төг/	782,107.7	193,422.0
15	Активын өгөөж /ROA/	1.9 %	0.44 %

2011 оны хоёрдугаар улиралд нийт 171 хоршоо хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Тусгай зөвшөөрөлтэй хоршоодын байршлыг үзүүлвэл:



Тайлант улиралд 171 хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хоршоодоос Улаанбаатар хотод 73 хоршоо, орон нутагт 98 хоршоо үйл ажиллагаагаа явуулж байна.

2.2 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй хоршоодын статистик үзүүлэлтүүд

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны II улирал
1	УБ хотод үйл ажиллагаа явуулж буй хоршоодын тоо	73
2	Гишүүдийн тоо	11.515
	Хоршооны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь	43.7%
3	Нийт актив /мян.төг/	45,669,158.5
	Хоршооны нийт активт эзлэх хувь	85.8%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	34,314,276.5
	Хоршооны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	84.8%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мян.төг/	2,343,584.2
	Хоршооны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь	80.4%
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл /мян.төг/	34,309,315.4
	Хоршооны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь	90.5%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мян.төг/	5,453,372.4
	Хоршооны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь	69.3%
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн /мян.төг/	3,207,711.9
	Хоршооны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь	83.2%
9	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мян.төг/	54,621.4
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мян.төг/	2,624,883.9
11	Нийт орлого /мян.төг/	5,161,990.6
12	Нийт зардал /мян.төг/	4,687,333.9
13	Тухайн үеийн ашиг, алдагдал /мян.төг/	474,656.7

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 73 хоршоо нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын 42.7 хувийг, тэдгээрийн нийт актив 45,669,158.5 мянган төгрөг байгаа нь нийт активын 85.8 хувийг тус тус эзэлж байна.

Эдгээр 73 хоршоо нь 5,161,990.6 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь нийт хадгаламж, зээлийн хоршоодын орлогын 81.7 хувийг, харин 4,687,333.9 мянган төгрөгийн зардал гаргасан нь нийт хоршоодын зардлын 84.7 хувийг тус тус эзэлж байна.

2.3 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодын статистик үзүүлэлтүүд

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны II улирал
1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодын тоо	98
2	Гишүүдийн тоо	14.814
	Хоршооны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь	56.3%
3	Нийт актив /мян.төг/	7,581,335.0
	Хоршооны нийт активт эзлэх хувь	14.2%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	6,139,446.3
	Хоршооны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	15.2%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мян.төг/	569,694.7
	Хоршооны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь	19.6%
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл /мян.төг/	3,611,024.7

	Хоршооны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь	9.5%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мян.төг/	2,416,786.1
	Хоршооны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь	30.7%
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн /мян.төг/	646,653.2
	Хоршооны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь	16.8%
9	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мян.төг/	430,235.6
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мян.төг/	178,107.4
11	Нийт орлого /мян.төг/	1,156,798.3
12	Нийт зардал /мян.төг/	849,347.3
13	Тухайн үеийн ашиг /мян.төг/	307,451.0

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 98 хоршоо нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын 57.3 хувийг, тэдгээрийн нийт актив 7,581,335.0 мянган төгрөг байгаа нь нийт активын 14.2 хувийг тус тус эзэлж байна.

Эдгээр 98 хоршоо нь 1,156,798.3 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь нийт хадгаламж, зээлийн хоршоодын орлогын 18.3 хувийг, харин 849,347.3 мянган төгрөгийн зардал гаргасан нь нийт хоршоодын зардлын 15.3 хувийг тус тус эзэлж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодын гишүүдийн тоог графикаар үзүүлбэл:



2.4 Хасбанкны франчайзын² гэрээтэй ажиллаж буй хоршоодын статистик үзүүлэлтүүд

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны II улирал
1	Хас банктай франчайзын үйлчилгээний гэрээтэй хоршоодын тоо	60
2	Гишүүдийн тоо	10,019
	Хоршооны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь	38.0%
3	Нийт актив /мян.төг/	3,893,976.8
	Хоршооны нийт активт эзлэх хувь	7.3%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	3,206,675.3
	Хоршооны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	7.9%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мян.төг/	82,046.5

² Хорооноос 2009 оны 6 дугаар сарын 23-ны өдөр ХасБанктай байгуулсан 1/1711 тоот харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд 2011 оны II улирлын байдлаар “Хөгжлийн Хөтөч” франчайзын үйлчилгээнд хамрагдаж гэрээ байгуулан ажиллаж байгаа нийт 60 хоршоод байна.


	Хоршооны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь	2.8%
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл /мян.төг/	1,227,278.1
	Хоршооны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь	3.2%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мян.төг/	1,528,295.7
	Хоршооны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь	19.4%
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн /мян.төг/	448,156.1
	Хоршооны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь	11.6%
9	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мян.төг/	430,235.6
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мян.төг/	178,107.4
11	Нийт орлого /мян.төг/	675,538.2
12	Нийт зардал /мян.төг/	454,111.4
13	Тухайн үеийн ашиг, алдагдал /мян.төг/	221,426.8

Тайлан нэгтгэх өдрийн байдлаар Хасбанктай франчайзын гэрээтэй 60 хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Тайлант улиралд Баянлхам, Ландо, Өсөн дэвжих жаргалтхаан, Манхан хөгжил хоршоод буюу нийт 4 хоршоо³ хэвийн үйл ажиллагаа явуулж чадаагүй, Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг удаа дараалан биелүүлээгүй тул хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

Франчайзын гэрээтэй хоршоодын орлого, зарлагын тайлангаас харахад 675,538.2 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт орлогын 10.7 хувийг, харин 454,111.4 мянган төгрөгийн зардал нь нийт зардлын 8.2 хувийг эзэлж байна. Тайлант улиралд 221,426.8 мянган төгрөгийн ашигтай ажилласан байгаа нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодын тухайн үеийн ашгийн 28,3 хувийг эзэлж байна.

Хасбанктай франчайзын гэрээтэй ажиллаж байгаа хоршоодын тоо болон гишүүдийн тоог орон нутаг бүрээр гаргавал:

³ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1.4 /тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн/, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 25.1.8 /тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжийг ноцтой буюу удаа дараа зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг хичингүй болгох талаар Хороонд санал оруулах/.



Тайлант хугацаанд нийт 171 хоршоо ажиллаж байгаагаас 136 хоршоо 1,088,990.9 мянган төгрөгийн ашигтай ажилласан бөгөөд үүнээс Хасбанктай франчайзын гэрээтэй 51 хоршоо нийт 227,033.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй ашигтай ажилласан хоршоодын 20.8 хувийг эзэлж байна.

Харин Хасбанктай франчайзын гэрээтэй 9 хоршоо нийт 5,606.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь орон нутагт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй алдагдалтай ажилласан хоршоодын нийт алдагдлын 28.2 хувийг эзэлж, нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй алдагдалтай ажилласан хоршоодын 1.8 хувийг эзэлж байна.

ГУРАВ. ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Орлогын үзүүлэлтүүд

Эхний хагас жилд нийт орлогын хэмжээ 6,318,789.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 345,415.2 мянган төгрөгөөр буюу 5.8 хувиар өссөн нь зээлийн хүүгийн орлого, үйл ажиллагааны бусад орлогын өсөлтийн өөрчлөлт нөлөөлжээ.

Орлогын бүтцийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2011.06.30		2010.06.30		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
ХҮҮГИЙН ОРЛОГО	5,828,230.8	92.2%	5,215,387.6	87.3%	612,843.2	11.8
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	5,561,950.8	88.0%	4,948,551.8	82.8%	613,398.9	12.4
Зээлийн нэмэгдүүлсэн хүү, алдангийн орлого	78,402.5	1.2%	66,298.6	1.1%	12,103.9	18.3
Банкнаас авсан харилцах, хадгаламжийн хүүгийн орлого	161,700.1	2.6%	165,160.0	2.8%	- 3,459.9	-2.1
Бусад байгууллагаас авсан хүүгийн орлого	2,977.0	0.0%	2,576.0	0.0%	401.0	0.0
Бусад хүүгийн орлого	23,200.5	0.4%	32,801.2	0.5%	- 9,600.7	-29.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД	326,757.9	5.2%	170,190.9	2.9%	156,567.0	92.0

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын 2011 оны хоёрдугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

ОРЛОГО						
Элсэлтийн хураамж	7,207.3	0.1%	5,944.9	0.1%	1,262.4	21.2
Гишүүний татвар	19,847.6	0.3%	15,351.8	0.3%	4,495.8	29.3
Үйлчилгээний хураамж	66,022.9	1.0%	42,444.0	0.7%	23,578.9	55.6
Үйл ажиллагааны бусад орлого	233,680.1	3.7%	106,450.2	1.8%	127,229.9	119.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	163,800.2	2.6%	587,795.3	9.8%	- 423,995.0	-72.1
Торгуулийн орлого	169.5	0.0%	100.0	0.0%	69.5	69.5
Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын орлого	1,825.3	0.0%	20,650.1	0.3%	- 18,824.8	-91.2
ӨБҮХХ борлуулснаар олсон орлого	10,000.0	0.2%		0.0%	10,000.0	0.0
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	100,574.2	1.6%	483,907.7	8.1%	- 383,333.5	-79.2
Тэнцлийн гадуурх тооцооноос орсон орлого	20,980.2	0.3%	27,817.7	0.5%	- 6,837.5	-24.6
Бусад орлого	23,468.9	0.4%	35,727.0	0.6%	- 12,258.0	-34.3
Онцгой шинжтэй орлого	6,582.7	0.1%	18,249.5	0.3%	- 11,666.8	-63.9
Ердийн бус орлого	199.4	0.0%	1,343.2	0.0%	- 1,143.8	-85.2
Нийт орлогын дүн	6,318,789.0	100.0%	5,973,373.8	100.0%	345,415.2	5.8

Тайлант улиралд нийт орлогын 88.0 хувийг зээлийн хүүгийн орлого, 2.6 хувийг үйл ажиллагааны бус орлого, 5.2 хувийг элсэлтийн хураамж, гишүүний татвар, үйлчилгээний хураамж, үйл ажиллагааны бусад эзэлж байна.

3.2 Зардлын үзүүлэлтүүд

Тайлант улиралд нийт зардлын хэмжээ 5,536,681.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 243,270.6 мянган төгрөгөөр буюу 4.2 хувиар буурсан, үйл ажиллагааны бусад зардал 588,889.4 мянган төгрөгөөр, зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн зардал 201,479.2 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардлын 64.4 хувийг хүүгийн зардал, 8.6 хувийг болзошгүй эрсдэлийн сангийн зардал, 23.1 хувийг үйл ажиллагааны зардал, 3.9 хувийг үйл ажиллагааны бус зардал тус тус эзэлж байна. Харин нийт зардлын 1.7 хувийг гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 86,5 хувиар буурчээ. Энэ нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль⁴ хэрэгжиж гишүүдээс гадаад валютаар хадгаламж татан төвлөрүүлэх, гадаад валютаар зээл олгохыг хориглосонтой холбоотой байна.

Зардал дараах бүтэцтэй байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2011.06.30		2010.06.30		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
ХҮҮГИЙН ЗАРДАЛ	3,570,084.9	64.4%	3,128,223.2	54.1%	441,861.7	14.1
Хугацаагүй хадгаламжийн хүүгийн зардал	1,680,266.6	30.3%	1,495,163.7	25.9%	185,102.9	12.4
Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1 жил хүртэлх хугацаатай)	1,562,856.7	28.2%	1,140,676.8	19.7%	422,180.0	37.0
Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1-ээс дээш жилийн хугацаатай)	236,101.2	4.3%	407,156.0	7.0%	- 171,054.8	-42.0
Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	64,806.2	1.2%	70,062.4	1.2%	- 5,256.2	-7.5
Бусад хүүгийн зардал	26,054.2	0.5%	15,164.4	0.3%	10,889.8	71.8
БОЛЗОШГУЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН	474,458.0	8.6%	675,937.2	11.7%	- 201,479.2	-29.8

⁴ Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль 2009 оны 7 дугаар сарын 09-ны өдөр батлагдан гарсан.

ЗАРДАЛ						
Зээлийн болзошгүй эрсдэлийн зардал	448,593.1	8.1%	633,316.1	11.0%	- 184,723.1	-29.2
Авлагын болзошгүй эрсдэлийн зардал	6,474.0	0.1%	1,961.6	0.0%	4,512.4	230.0
Өмчлөх бусад үндсэн хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал	5,249.6	0.1%	40,388.6	0.7%	- 35,139.0	-669.4
Бусад эрсдэлийн зардал	14,141.4	0.3%	270.9	0.0%	13,870.5	5120.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,279,782.0	23.1%	1,171,545.7	20.3%	105,236.3	9.0
Боловсон хүчний зардал	794,825.9	14.4%	667,958.1	11.6%	126,867.8	19.0
Бусад зардал	481,956.1	8.7%	503,587.6	8.7%	- 21,631.5	-4.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	215,356.4	3.9%	804,245.8	13.9%	- 588,889.4	-73.2
Торгуулийн зардал	5,575.3	0.1%	5,040.5	0.1%	534.8	10.6
Ногдол ашгийн зардал		0.0%	19.8	0.0%	- 19.8	-100.0
Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын гарз	198.0	0.0%	2,116.3	0.0%	- 1,918.3	-90.6
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал	95,322.0	1.7%	708,459.9	12.3%	- 613,137.9	-86.5
Үйл ажиллагааны бус бусад зардал	6,602.7	0.1%	11,349.7	0.2%	- 4,746.9	-41.8
Ердийн бус зардал	168.1	0.0%	140.2	0.0%	27.9	19.9
Татварын зардал	107,490.2	1.9%	77,119.4	1.3%	30,370.8	39.4
Нийт зардлын дүн	5,536,681.3	100.0%	5,779,951.8	100.0%	- 243,270.6	-4.2

Тайлант улирлын зардлын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт зардалд эзлэх хүүгийн зардал 54.1-64.5 хувь болж 14.1 хувиар, үйл ажиллагааны зардал 20.3-23.1 хувь болж 9,0 хувиар тус тус өссөн, харин болзошгүй эрсдэлийн сангийн зардал 11.7-8.6 хувь болж 3.1 хувиар, үйл ажиллагааны бус зардал 13.9-3.9 хувь болж 10,0 хувиар тус тус буурсан байна.

Тайлант хугацааны цэвэр ашгийг үзүүлвэл:

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2011.06.30		2010.06.30		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Нийт орлогын дүн	6,318,789.0	100.0%	5,973,373.8	100.0%	345,415.2	5.8
Нийт зардлын дүн	5,536,681.3	100.0%	5,779,951.8	100.0%	- 243,270.6	-4.2
Ашиг	782,107.7		193,422.0		588,685.8	

3.3 Алдагдалтай ажиллаж буй хоршоод

Нийт 171 хоршоо хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 35 хоршоо буюу 20.5 хувь нь нийт 306,883.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Үүнд:

д/д	Үзүүлэлтүүд	Хоршоодын тоо	Нийт алдагдал /мянган төгрөгөөр/	Эзлэх хувь
1	100,000.0 мянган төгрөгөөс дээш	1	201,696.2	65.7%
2	10,000.0-100,000.0 мянган төгрөг	3	54,930.3	17.9%
3	1,000.0-10,000.0 мянган төгрөг	12	43,533.3	14.2%
4	100.0-1,000.0 мянган төгрөг	13	6,386.5	2.1%
5	100.0 мянган төгрөг хүртэл	6	336.9	0.1%
	Нийт дүн	35	306,883.2	100.0%

Нийт алдагдалтай ажиллаж байгаа хоршоодын 62.9 хувь буюу 22 хоршоо нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа, тэдгээрийн алдагдал 287,012.7 мянган төгрөг байгаа нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт алдагдлын 93.5 хувийг эзэлж байна.

Орон нутагт алдагдалтай ажиллаж байгаа 13 хоршооны 19,870.5 мянган төгрөгийн алдагдал нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт алдагдлын 6.5 хувийг, Хасбанктай франчайзын гэрээтэй 9 хоршоо нийт 5,606.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь орон нутагт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй алдагдалтай ажилласан хоршоодын нийт алдагдлын 28.2 хувийг эзэлж байна.

Алдагдалтай ажиллаж буй хоршоодын нийт пассив хөрөнгө буюу өр төлбөр ба өөрийн хөрөнгийн 79,2 хувийг өр төлбөр, 20.8 хувийг өөрийн хөрөнгө⁵ тус тус эзэлж байна.

3.4 Ашигтай ажиллаж буй хоршоод⁶

Тайлант улиралд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 171 хоршоодын 79,5 хувь буюу 136 хоршоо нь 1,088,990.9 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Ашгийн хэмжээгээр хоршоодыг ангилахад дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Ашгийн үзүүлэлтүүд	Хоршооны тоо	Нийт ашиг /мянган төгрөгөөр/	Ашигт эзлэх хувь
1	100,000.0-300,000.0 мянган төгрөг хүртэл	1	204,871.5	18.8%
2	50,000.0-100,000.0 мянган төгрөг хүртэл	5	328,871.3	30.2%
3	10,000.0-50,000.0 мянган төгрөг хүртэл	19	340,405.8	31.2%
4	5,000.0-10,000.0 мянган төгрөг хүртэл	13	89,109.7	8.1%
5	1,000.0-5,000.0 мянган төгрөг хүртэл	44	106,629.8	9.8%
6	500.0-1,000.0 мянган төгрөг хүртэл	15	9,811.9	0.9%
7	100.0-500.0 мянган төгрөг хүртэл	31	9,102.7	0.8%
8	100.0 мянган төгрөг хүртэл	8	188.2	0.02%
	Нийт дүн	136	1,088,990.9	100.0%

Нийт ашигтай ажиллаж байгаа хоршоодын 37.5 хувь буюу 51 хоршоо нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн нийт ашиг нь 770,252.7 мянган төгрөг буюу ашигтай ажиллаж байгаа хоршоодын нийт ашгийн 70,7 хувийг, нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын тайлангийн үеийн ашгийн 98.5 хувийг тус тус эзэлж байна.

Мөн нийт ашигтай ажиллаж байгаа хоршоодын 62.5 хувь буюу 85 хоршоо нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн нийт ашиг нь 318,738.2 мянган төгрөг буюу ашигтай ажиллаж байгаа хоршоодын нийт ашгийн 29,3 хувийг, нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын тайлангийн үеийн ашгийн 40.7 хувийг тус тус эзэлж байна.

⁵ Хоршооны тухай хуулийн 5.1-д “Хоршоо нь үйл ажиллагааныхаа улмаас бий болсон иргийг зөвхөн өөрийн /хоршооны/ эд хөрөнгөөр хариуцна. 5.2-д “Хоршооны эд хөрөнгө хирэлцэхгүй тохиолдолд түүний иргийг гишүүд нь нөхөж хариуцна. Гишүүдийн хилээх нөхөж хариуцлагын хэмжээг хязгаарлах эсэхийг дүрмээр зохицуулна”. 5.3-д “Хадгаламж, зээлийн хоршоо үйл ажиллагааныхаа улмаас бий болсон иргийг өөрийн хөрөнгөөр хилээнэ.”

⁶ Өнөөгийн мөрдөгдөж байгаа Иргэний хуулийн 33.2-д “Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна”

Ашигтай ажиллаж байгаа хоршоодын 37.5 хувь буюу 51 хоршоо нь Хасбанктай франчайзын гэрээтэй хоршоод бөгөөд тэдгээрийн нийт ашиг 227,033.4 мянган төгрөг буюу ашигтай ажиллаж байгаа хоршоодын нийт ашгийн 20,8 хувийг, харин нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын тайлангийн үеийн ашгийн 29.0 хувийг тус тус эзэлж байна.

ДӨРӨВ. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

4.1 Активын чанар

Хоршоодын тайлант улирлын нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2011.06.30		2010.06.30		Өөрчлөлт	
	дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	51,927,281.6	97.5%	44,540,882.5	97.5%	7,386,399.0	16.6%
МӨНГӨН ХӨРӨНГӨ	10,064,236.5	18.9%	7,611,434.3	18.2%	2,452,802.2	32.2%
1.Касс дахь бэлэн мөнгө	1,519,654.6	2.9%	1,398,144.3	3.3%	121,510.3	8.7%
2.Банкинд байршуулсан харилцах	5,020,210.7	9.4%	3,437,578.9	8.7%	1,582,631.7	46.0%
3.Банкинд байршуулсан хадгаламж	3,524,371.3	6.6%	2,775,711.1	6.2%	748,660.2	27.0%
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	38,052,612.1	71.5%	33,311,403.2	72.0%	4,741,208.9	14.2%
8. Нийт зээл	40,453,722.9	76.0%	35,481,217.6	76.9%	4,972,505.3	14.0%
8.1.Хэвийн зээл	36,600,133.1	68.7%	29,046,591.7	61.4%	7,553,541.4	26.0%
8.2.Хугацаа хэтэрсэн зээл	940,310.9	1.8%	3,034,399.7	8.3%	(2,094,088.8)	-69.0%
8.3.Чанаргүй зээл	3,165,385.6	5.9%	3,400,226.2	7.2%	(234,840.6)	-6.9%
8.3.1. Хэвийн бус	452,342.7	0.8%	1,219,186.0	3.2%	(766,843.2)	-62.9%
8.3.2. Эргэлзээтэй зээл	361,127.1	0.7%	855,314.2	0.7%	(494,187.1)	-57.8%
8.3.3. Муу зээл	2,099,809.0	3.9%	1,325,726.0	3.3%	774,083.0	58.4%
8.4.(Зээлийн эрсдэлийн сан)	2,401,110.8	4.5%	2,169,814.4	-4.8%	231,296.4	10.7%
АВЛАГА (ЦЭВРЭЭР)	2,991,170.2	5.6%	2,842,045.3	5.8%	149,124.9	5.2%
9. Байгууллага, хүмүүсээс авах авлага	353,509.4	0.7%	359,900.6	0.7%	(6,391.2)	-1.8%
10. (Байгууллага, хүмүүсээс авах авлагын эрсдлийн сан)	59,830.1	0.1%	43,711.5	0.1%	16,118.6	36.9%
11. Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	2,697,490.9	5.1%	2,525,856.2	5.2%	171,634.7	6.8%
БУСАД ХӨРӨНГӨ	231,346.6	0.4%	170,156.7	0.4%	61,189.9	36.0%
12. Материал үнэ бүхий зүйл	149,572.0	0.3%	109,437.0	0.3%	40,135.0	36.7%
14. Урьдчилж төлсөн зардал, тооцоо	30,867.3	0.1%	15,486.5	0.0%	15,380.7	99.3%
15. Бусад актив	50,907.3	0.1%	45,233.2	0.1%	5,674.1	12.5%
ӨМЧЛӨХ БУСАД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	587,916.1	1.1%	605,843.0	1.1%	(17,926.9)	-3.0%
16. Өмчлөх бусад хөрөнгө	620,472.8	1.2%	694,221.4	1.2%	(73,748.6)	-10.6%
17. (Өмчлөх бусад хөрөнгийн эрсдлийн сан)	32,556.7	0.1%	88,378.4	0.1%	(55,821.7)	-63.2%
2.ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	1,323,212.0	2.5%	1,054,263.5	2.5%	268,948.5	25.5%
ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	1,218,685.7	2.3%	956,277.8	2.2%	262,407.9	27.4%
18. Үндсэн хөрөнгө	1,673,239.9	3.1%	1,398,971.6	3.3%	274,268.3	19.6%
19.(Үндсэн хөрөнгийн элэгдэл)	454,554.2	0.9%	442,693.8	1.1%	11,860.4	2.7%
БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	104,526.3	0.2%	97,985.7	0.2%	6,540.6	6.7%

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын 2011 оны хоёрдугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

20. Биет бус хөрөнгө	20,830.6	0.0%	23,166.4	0.1%	(2,335.8)	-10.1%
21.Бусад	83,695.7	0.2%	74,819.3	0.2%	8,876.4	11.9%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (1+2)	53,250,493.5	100.0%	45,595,146.0	100.0%	7,655,347.5	16.8%

Салбарын тайлант улирлын нийт активын бүтцийг гаргавал:



Тайлант улиралд активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7,655,347.5 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь хугацаатай хадгаламж 5,849,821.0 мянган төгрөгөөр, хугацаагүй хадгаламж 1,059,275.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад мөнгөн хөрөнгө 2,452,802.2 мянган төгрөгөөр, нийт зээл 4,972,505.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, зээлийн чанар сайжирсан байна.

Салбарын хэмжээгээр нийт активын өсөлтийг графикаар гаргавал:



Активын төвлөрлийн байдлыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Активын хэмжээ	Хоршоодын тоо	Нийт актив /мянган төгрөгөөр/	Нийт активт эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	21,201,542.3	39.8%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	5	15,098,544.6	28.4%

3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	8	5,278,560.9	9.9%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	38	7,935,924.8	14.9%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	28	2,022,852.3	3.8%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	67	1,570,991.1	3.0%
7	5,000.0-10,000.0 мянган төгрөг	14	105,188.1	0.2%
8	5,000.0 мянган төгрөг хүртэл	10	36,889.2	0.0%
	Нийт дүн	171	53,250,493.5	100.0%

Активын төвлөрлийг ангилахад томоохон буюу 679,556.4-21,201,542.3 мянган төгрөгийн активтай нийт 10 хоршооны нийт актив нь 39,339,428.8 мянган төгрөг бөгөөд нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 171 хоршоодын нийт активын 73.9 хувийг эзэлж байна.

4.2 Зээлийн багцын чанар


Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2011.06.30	хувь	2009.06.30	хувь	ӨӨРЧЛӨЛТ	
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	38,052,612.1	71.5%	33,311,403.2	72.0%	4,741,208.9	14.2%
Нийт зээл	40,453,722.9	76.0%	35,481,217.6	76.9%	4,972,505.3	14.0%
Хэвийн зээл	36,600,133.1	68.7%	29,046,591.7	61.4%	7,553,541.4	26.0%
Хугацаа хэтэрсэн зээл	940,310.9	1.8%	3,034,399.7	8.3%	(2,094,088.8)	-69.0%
Чанаргүй зээл	3,165,385.6	5.9%	3,400,226.2	7.2%	(234,840.6)	-6.9%
<i>Хэвийн бус</i>	452,342.7	0.8%	1,219,186.0	3.2%	(766,843.2)	-62.9%
<i>Эргэлзээтэй зээл</i>	361,127.1	0.7%	855,314.2	0.7%	(494,187.1)	-57.8%
<i>Муу зээл</i>	2,099,809.0	3.9%	1,325,726.0	3.3%	774,083.0	58.4%
(Зээлийн эрсдэлийн сан)	2,401,110.8	4.5%	2,169,814.4	-4.8%	231,296.4	10.7%

Тайлант улиралд нийт зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,741,208.9 мянган төгрөгөөр буюу 14.2 хувиар өссөн, хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2,094,088.8 мянган төгрөг буюу 69.0 хувиар, зээлийн эрсдэлийн санг 231,296.4 мянган төгрөг буюу 6.9 хувиар буурч, нийт зээлийн багцын 5.9 хувийг тус тус эзэлж зээлийн багцын чанар сайжирсан байна. (Зээлийн эрсдэлийн санг системийн хэмжээгээр 39,363.0 мянган төгрөгөөр дутуу байгуулсан)

Зээлийн багцыг графикаар харуулбал:



Энэ нь тайлант үеийн ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 588,685.8 мянган төгрөгөөр өсөхөд эерэгээр нөлөөлсөн байна.

Хоршоодын зээлийн өрийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Зээлийн дүн /интервалаар/	Хоршоодын тоо	Нийт зээлийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	Нийт зээлд эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	15,890,692.3	39.3%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	5	10,922,778.4	27.0%
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	4	2,703,644.7	6.7%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	33	7,170,676.5	17.7%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	28	2,066,282.8	5.1%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	63	1,515,005.8	3.7%
7	5,000.0-10,000.0 мянган төгрөг	16	116,068.5	0.3%
8	5,000.0 мянган төгрөг хүртэл	20	68,573.7	0.2%
9	Зээлийн үлдэгдэлгүй	1		
		171	40,453,722.8	100.00%

Зээлийн өрийн үлдэгдлийг бүлэглэхэд ихээхэн хэмжээний буюу 500,000.0 мянган төгрөгөөс дээш зээлийн өрийн үлдэгдэлтэй нийт 10 хоршооны зээлийн өрийн үлдэгдэл 29,517,115.4 мянган төгрөг байгаа нь нийт хоршоодын олгосон зээлийн өрийн үлдэгдлийн 72.9 хувийг эзэлж байна.


ТАВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Хоршоодын тайлант улирлын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Тухайлбал:

ҮЗҮҮЛЭЛТ	2011.06.30		2010.06.30		Өөрчлөлт	
	Дүн	хувь	Дүн	хувь	Дүн	хувь
1. ӨР ТӨЛБӨР	41,525,969.9	78.0%	34,958,326.5	74.7%	6,567,643.4	-12.7%

ХАДГАЛАМЖ	37,920,340.1	71.2%	31,011,243.7	68.0%	6,909,096.4	22.3%
1. Хугацаагүй	2,671,327.3	5.0%	1,612,051.9	3.9%	1,059,275.4	65.7%
2. Хугацаатай	35,249,012.8	66.2%	29,399,191.9	64.1%	5,849,821.0	19.9%
БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ	484,857.0	0.9%	558,558.8	1.2%	- 73,701.8	-13.2%
3. Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл	435,257.1	0.8%	555,201.4	1.2%	- 119,944.3	-21.6%
4. Богино хугацаат төслийн санхүүжилт	49,600.0	0.1%	3,357.4	0.0%	46,242.6	1377.3%
БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,923,411.8	5.5%	3,158,205.3	4.9%	- 234,793.5	-7.4%
5. Татварын төлөх өглөг	75,868.1	0.1%	61,557.0	0.1%	14,311.1	23.2%
6. Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	2,263,598.0	4.3%	2,117,370.1	4.1%	146,227.9	6.9%
7. Өглөг	520,020.8	1.0%	914,349.3	0.4%	- 394,328.5	-43.1%
8. Бусад пассив	63,924.9	0.1%	64,928.9	0.4%	- 1,004.0	-1.5%
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	197,360.9	0.4%	230,318.6	0.5%	- 32,957.7	-14.3%
8. Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээл	192,022.8	0.4%	230,318.6	0.5%	- 38,295.8	-16.6%
9. Урт хугацаат төслийн санхүүжилт	5,338.1		-		5,338.1	
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	11,724,523.6	22.0%	10,636,819.6	25.3%	1,087,704.1	21.8%
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ	7,870,158.6	14.8%	7,220,707.7	16.7%	649,450.9	9.0%
10. Хувь нийлүүлсэн хөрөнгө	7,870,158.6	14.8%	7,220,707.7	16.7%	649,450.9	9.0%
ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ	3,854,365.1	7.2%	3,416,111.9	8.6%	438,253.2	12.8%
11. Нөөцийн сан	1,754,779.4	3.3%	1,481,753.2	3.3%	273,026.2	18.4%
12. Дахин үнэлгээний сан	266,969.5	0.5%	92,360.7	0.2%	174,608.7	189.1%
13. Нийгмийн хөгжлийн сан	268,820.3	0.5%	203,245.8	0.4%	65,574.5	32.3%
14. Бусад сангууд	121,169.9	0.2%	132,116.0	0.3%	- 10,946.0	-8.3%
15. Хандив, тусламж	68,363.5	0.1%	39,075.1	0.1%	29,288.4	75.0%
16. Бусад өмч	265,440.0	0.5%	53,043.7	0.0%	212,396.3	400.4%
17. Тайлангийн үеийн ашиг/алдагдал	782,107.7	1.5%	193,422.0	-0.1%	588,685.8	304.4%
18. Хуримтлагдсан ашиг/алдагдал	326,714.8	0.6%	1,221,095.6	4.4%	- 894,380.8	-73.2%
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ ДҮН (1+2)	53,250,493.5	100.0%	45,595,146.0	100.0%	7,655,347.5	9.2%

Салбарын тайлант улирлын нийт пассивын бүтцийг гаргавал:



Тайлант улиралд гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,909,096.4 мянган төгрөгөөр буюу 22.3 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгө 649,450.9 мянган төгрөг буюу 9.0 хувиар, хоршоологчдын өмч 438,253.2 мянган төгрөгөөр буюу 12.8 хувиар тус тус өссөн байна. Хоршоологчдын өмчийн өсөлтөд нөөцийн сангийн хэмжээ 273,026.2 мянган төгрөгөөр, дахин үнэлгээний сан 174,608.7 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ. Харин банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл, урт хугацаат өр төлбөрийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 341,453.0 мянган төгрөгөөр буюу 34.9 хувиар буурчээ.

Хоршоодын гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг бүлэглэн харуулвал:

д/д	Хадгаламжийн дүн /интервалаар/	Хоршоодын тоо	Нийт хадгаламжийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	Нийт хадгаламжид эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	16,808,820.1	44.3%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	3	11,104,767.4	29.3%
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	5	3,515,674.1	9.3%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	19	4,126,641.8	10.9%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	17	1,175,181.6	3.1%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	46	1,003,060.9	2.6%
7	1,000.0-10,000.0 мянган төгрөг	40	178,700.5	0.5%
8	1,000.0 мянган төгрөг хүртэл	40	7,493.5	0.0%
9	Хадгаламжгүй	23	-	
	Нийт дүн	171	37,920,340.1	100.0%

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад томоохон буюу 500,000.0 мянган төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй нийт 9 хоршооны нийт хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ 31,429,261.7 мянган төгрөг нь хоршоодын нийт хадгаламжийн үлдэгдлийн 82.9 хувийг эзэлж байна.

Хадгаламж татан төвлөрүүлээгүй нийт 23 хоршоо байгаа бөгөөд нийт хоршоодын 13.4 хувийг эзэлж, зөвхөн өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хувь нийлүүлсэн хөрөнгө тайлант улиралд 7,870,158.6 мянган төгрөг байгаа бөгөөд бүлэглэж харуулбал:

д/д	ХНХ-ийн үзүүлэлт	Хоршооны тоо	ХНХ-ийн хэмжээ /мянган төгрөгөөр/	Нийт ХНХ-ийн хэмжээнд эзлэх хувь
1	2,000,000.0 мянган төгрөгөөс дээш	3	3,148,952.5	40.0%
2	100,000.0-500,000.0 мянган төгрөг	6	1,156,350.4	14.7%
3	50,000.0-100,000.0 мянган төгрөг	19	1,274,937.1	16.2%
4	15,000.0-50,000.0 мянган төгрөг	56	1,621,303.9	20.6%
5	10,000.0-15,000.0 мянган төгрөг	27	343,228.5	4.4%
6	5,000.0-10,000.0 мянган төгрөг	30	228,238.3	2.9%
7	1,000.0-5,000.0 мянган төгрөг	30	97,147.8	1.2%
	Нийт дүн	171	7,870,158.5	100.0%

Хадгаламж, зээлийн хоршоодын хоршоологчдын өмч 3,854,365.1 мянган төгрөг байгаа бөгөөд интервалаар харуулбал:

д/д	ХНХ-ийн үзүүлэлт	Хоршооны тоо	Хоршоологчдын өмчийн дүн /мянган төгрөгөөр	Нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь
1	100,000.0-500,000.0 мянган төгрөг	9	2,561,084.5	66.4%
2	50,000.0-100,000.0 мянган төгрөг	8	479,145.0	12.4%
3	15,000.0-50,000.0 мянган төгрөг	28	797,668.8	20.7%
4	1,000.0-10,000.0 мянган төгрөг	37	316,255.4	8.2%
5	1,000.0 мянган төгрөг хүртэл	48	125,987.7	3.3%
6	1,0-1,000.0 мянган төгрөг	15	7,234.2	0.2%
7	Хоршоологчдын өмчгүй ⁷ /алдагдалтай/	26	-5,433,010.4	-11.2%
	Нийт дүн	171	3,854,365.1	100.0%

ЗУРГАА. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ХОРШООДЫГ АКТИВААР БҮЛЭГЛЭСЭН ТАЛААР

Хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодод хийж буй газар дээрх шалгалтыг үр өгөөжтэй зохион байгуулах, чанаржуулах, нэг бүлэгт хамаарагдаж буй хоршоодыг харьцуулах замаар тэдгээрийн санхүү, төлбөрийн чадварын байдалд бодит үнэлгээ өгөх зорилгоор хадгаламж, зээлийн хоршоодын активын хэмжээгээр нь 4 ангилж дараах байдлаар бүлэглэсэн. Үүнд:

Бүлгийн дугаар	Бүлэглэсэн активын интервал	Бүлэгт багтах хоршоодын тоо	Эзлэх хувь	Үүнээс	
				УБ хотод үйл ажиллагаа явуулж буй хоршоодын тоо	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодын тоо
Бүлэг-1	50.0 сая төгрөг хүртэл	92	53.8%	33	59
Бүлэг-2	50-500.0 сая төгрөг	66	38.6%	29	37
Бүлэг-3	500.0-1.0 тэрбум төгрөг	8	4.7%	6	2
Бүлэг-4	1.0 тэрбумаас дээш	5	2.9%	5	-
	Нийт дүн	171	100.0%	73	98

Бодит үнэлгээ өгөхийн тулд бүлэг тус бүрээр зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тооцож гаргасан.

ДОЛОО. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр хувьд Хорооны 2008 оны 180 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны

⁷ Иргэний хуулийн 36.4-д “Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бийх дундын эд херенг дээр индэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.”

үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД		БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАНГААР
А АКТИВЫН ЧАНАРЫН БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН			
1	АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+ илүү, - дутуу) /мянган төгрөгөөр/	2,440,473.8	2,401,110.8 дутуу байгуулсан
2	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	7.2% хангаагүй
3	ЗЭЭЛИЙН ТӨВЛӨРЛИЙН ЭРСДЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (30 хувиас доош)	30.0%	0.0%
Б ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ			
4	НИЙТ АКТИВ ХӨРӨНГӨД ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ (50-80 хүртэлх хувь)	50%-80%	71.5%
5	ӨБҮХХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	1.1%
6	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	2.3%
7	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (80 хүртэлх хувь)	80.0%	71.2%
8	БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (10 хувиас хэтрэхгүй)	10.0%	1.2%
9	ГИШҮҮДИЙН ХНХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас дээш)	5.0%	14.8%
10	ГИШҮҮДИЙН ХОРШООЛОГЧДЫН ӨМЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (10 хувиас дээш)	10.0%	7.0% хангаагүй
11	НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	561,804,764.2	1,754,779,374.0
В ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ			
13	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ТҮВШИН (5 хувиас бага)	5.0%	2.4%
Г ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР			
14	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА (5 хувиас дээш)	5.0%	11.4%
Д ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ (ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ)			
15	АКТИВЫН ӨГӨӨЖ		1.9%
16	ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ		16.4%
17	ЗЭЭЛИЙН БАГЦЫН ӨГӨӨЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА		15.3%

Хоршоодын санхүүгийн тайлангийн нэгтгэлээс харахад чанаргүй зээлийн зохистой харьцаа 5.0 хувиас хэтрэхгүй байхаар хязгаарласан боловч нийт салбарын хувьд 2.2 хувиар хэтрүүлсэн, активын эрдэлийн санг 39,362.9 мянган төгрөгөөр дутуу байгуулсан, гишүүдийн хоршоологчдын өмчийн харьцаа нийт активын 10.0 хувиас хэтрэхгүй байхаар заасан боловч 3.0 хувиар дутуу зэрэг зөрчилтэй байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад чанаргүй зээлийн зохистой харьцааны хангаагүй хувь 2.4 хувиар буурч, гишүүдийн хоршоологчдын өмчийн хангаагүй хувь 0,5 хувиар өссөн байна. Харин бусад шалгуур үзүүлэлтүүдийг салбарын хэмжээгээр хангаж ажилласан байна.

НАЙМ. ДҮГНЭЛТ

Тайлант улиралд нийт 171 хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хоршоодоос Улаанбаатар хотод 73 хоршоо, орон нутагт 98 хоршоо үйл ажиллагаагаа явуулж, санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг хугацаанд нь ирүүлсэн 96 хоршоо буюу нийт хоршоодын 56,1 хувийг, хугацаа хоцроосон 54 хоршоо буюу нийт хоршоодын 31,6 хувийг, огт ирүүлээгүй 21 хоршоо буюу нийт хоршоодын 12,3 хувийг тус тус эзэлж байна.

Нийт 171 хоршоо 2011 оны хоёрдугаар улирлын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг Хороонд ирүүлэх ёстойгоос 2011 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 150 хоршоо тайлангаа ирүүлсэн нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодын 87,7 хувь бөгөөд хариуцсан хянан шалгагчид тайлангуудыг хянаж, нийт 150 хоршоонд тайлангийн хариуг явуулсан байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодоос 2009 оны зохицуулалт үйлчилгээний хөлс 13,260.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээс 2010 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 178 хоршооноос 12,713.9 мянган төгрөг буюу 95.9 хувийг төсөвт төвлөрүүлсэн бөгөөд нэг удаа төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлснөөс тусгай зөвшөөрлийн сунгалтын хураамж болох нийт 200,0 мянган төгрөг төлөхөөс 70,0 мянган төгрөг төлөгдсөн байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа системийн хувьд 11.4 хувьтай байгаа нь Хорооноос тогтоосон зохистой харьцааг хангаж байна.

Эхний хагас жилийн байдлаар хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн гол үзүүлэлтийг банкны салбарын мөн үзүүлэлттэй харьцуулахад нийт актив 0.7 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 0.9 хувь, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 0.8 хувь, татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл 1.1 хувийг тус тус эзэлж байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын хувь нийлүүлсэн хөрөнгө болон татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээг 2007-2011 оны хоёрдугаар улирал хүртэлх байдлаар харуулбал:



Эндээс үзэхэд хадгаламж, зээлийн хоршоодын хувь нийлүүлсэн хөрөнгө харьцангуй тогтмол байхад гишүүдээс татсан хадгаламжийн хэмжээ 2009 оноос хойш 16.0-4.0 хувийн өсөлттэй буюу нийт хувь нийлүүлсэн хөрөнгө, гишүүдээс татасан хадгаламжийн хоорондын харьцаа нь 24.7-20.0 хувьтай байна.

Гишүүдээс татсан хадгаламж, олгосон зээлийн хэмжээг 2007-2011 оны хоёрдугаар улирал хүртэлх байдлаар харуулбал:



Алдагдалтай ажиллаж буй хоршоодын нийт хөрөнгөд өр төлбөрийн хэмжээ нь 79.2 хувийг эзэлж харин өөрийн хөрөнгө дөнгөж 20.8 хувийг эзэлж байна. Энэ нь Хоршооны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3-т “Хадгаламж зээлийн хоршоо үйл ажиллагааныхаа улмаас бий болсон үүргийн өөрийн хөрөнгөөр хүлээнэ” гэж заасан хуулиар хүлээсэн хариуцлага алдагдсан байна гэж үзэж байна.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР